

МОНГОЛ УЛСААС ОХУ-ЫН БАЙГАЛИЙН БҮСИЙН СУБЪЕКТУУДАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

*К. Дэмбэрэл**

Монгол-Оросын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны агуулга, шинж чанар, зарчимд ихээхэн өөрчлөлтүүд гарч байна. Энэхүү харилцаа нь харилцан бие биеэ хүндэтгэсэн, харилцан ашигтай, тэгш эрхтэй байх үндсэн дээр явагдаж хамтын ажиллагааны олон хэлбэрээр баяжиж байна. Үндсэн хэлбэр гэвэл хамтарсан үйлдвэрийн газрууд, хил орчмын худалдаа, бүс нутгийн субъектуудын хамтын ажиллагаа, шинжлэх ухаан техник, соёл боловсролын болон жуулчлалын салбарт гэх мэт. Сүүлийн жилүүдэд дээрхи хэлбэрийн хамтын ажиллагаа идэвхжиж байна. Үүний тод жишээ гэвэл ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 онд Монгол улсад хийсэн албан ёсны айлчлал, 2002 онд ОХУ-ын Засгийн газрын тэргүүн М.Касьяновын айлчлал, мөн оны 6 сард ОХУ-ын Холбооны Зөвлөлийн Холбооны хурлын дарга С.Мироновын ажлын айлчлалууд билээ. Дээрхи айлчлалуудын үеэр хоёр орны харилцаанд буй эерэг, сөрөг асуудлаар илэн далангүй ярилцан цаашдын хамтын ажиллагааны талаар тодорхой чиглэл боловсруулах, мөн өөрсдөөс шалтгаалах бүхнийг хийхээ хоёр тал тохирсон. Ерөнхийлөгч В.В.Путины Монголд айлчлах үеэр гаргасан “Улаанбаатарын тунхаглал” нь хоёр орны харилцааны шинэ үеийг нээлээ хэмээн үзэж болно. Ер нь судлаачдын үзэж буйгаар энэхүү айлчлал нь хоёр талын хамтын ажиллагаанд нэмэлт хүчийг өгсөн гэхэд илүүдэхгүй.

Орчин үеийн хаирлцааны нэг онцлог бол Монгол, Оросын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд урьдхнаас илүү олон субъектууд оролцох болсон явдал билээ. Тийм хэдий ч засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагаа хэвийн бөгөөд идэвхитэй явагдаж байгаа. Эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн нь хоёр талын хооронд байгуулсан иж бүрэн гэрээ, хэлэлцээрүүд билээ. Засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагаа нь тодорхой арга хэмжээг шийдэх чиглэлд явагдаж ирлээ.

Өнөөдрийн байдлаар хамтын ажиллагааны ирээдүйтэй бөгөөд идэвхитэй хэлбэр нь хамтарсан үйлдвэр байгуулан ажиллах явдал гэдгийг практик харуулж байна. 2000 оны байдлаар Монголын нутаг дэвсгэр дээр монгол-оросын хамтарсан 150 гаруй үйлдвэр үйл

*К.Дэмбэрэл – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ажиллагаагаа явуулж байна. Эдгээрээс томоохон нь уулын баяжуулах “Эрдэнэт” комбинат, “Монроцветмет” нэгдэл, Монголын төмөр зам зэргүүд билээ. Түүнчлэн соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа идэвхжиж байна. Тэр нь 1995 оны засгийн газар хоорондын хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа. Энэ чиглэлийн хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдэд эрдэм шинжилгээний ажлууд, боловсон хүчин бэлтгэх, орос хэлний сургалт зэргүүд хамрагдаж байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд хувийн болон улсын зардлаар суралцагсдын тоо нэмэгдэж байгаа хэдий ч 70-80 –аад онтой харьцуулахад хэдэн арав дахин багассан билээ. Өнөөдөр ОХУ-д 300 хүрэхгүй шахам монгол оюутан улсын зардлаар сурч байна. Хувийн зардлаар суралцагсдын тоог тогтооход ч төвөгтэй. Зөвхөн Эрхүү, Москвад гэхэд тийм шугамаар суралцагсдын тоо 900 илүү байгаа. Мөн Монголд сурч буй Оросын оюутны тоо 150 хүрч нэмэгдлээ.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотноо орос хэл дээр сургалтаа явуулдаг хэд хэдэн хувийн сургуулиуд нээгдлээ. Эдгээр сургуулийн ихэнхи багш сурган хүмүүжүүлэгчид нь Эрхүү муж болон Буриад улсаас уригдан ирсэн туршлагатай багш нар билээ. Хоёр талын соёл шинжлэх ухааны хамтын ажиллагааг бүрэн утгаар нь хөгжүүлэхэд хоёр талын харилцан ашигтай, Монгол улсын ирээдүйн хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулах зорилготой байх нь зүй ёсны хэрэг.

Сүүлийн жилүүдийн монгол-оросын эдийн засгийн харилцааны онцлог бол хамтын ажиллагааны идэвхжил нь бүс нутгийн түвшинд идэвхжих болсон явдал, тухайлбал, Буриад, Тува улсууд, Алтай, Красноярскийн хязгаар, Эрхүү, Чита, Кемеров мужуудад илүү ажиглагдах боллоо. Монгол улс, ОХУ-ын хоорондын нийт бараа эргэлтэд Сибирийн бүсийн субъектуудын 70 илүү хувийг эзлэж байгаа ба түүнээс тал илүү нь гэхэд л Эрхүүгийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнүүд байгаа юм.

Монгол-Оросын хоорондын бүс нутгийн харилцаанд бүх талын, харилцан тэгш зарчимд тулгуурласан Монгол улсаас Эрхүү мужтай тогтоосон харилцаа чухал байр суурийг эзэлдэг. Эрхүү муж нь байгалийн асар их нөөц баялагтай бөгөөд зарим нь шинээр нээгдэн ашиглагдаж эхэлж ч байна. Нэн ялангуяа нефть, байгалийн хийн нөөцөөр арвин томоохон ордууд ашиглалтанд орж байна. Эрхүү мужийн нефтийн нийт нөөц нь 260 сая тн., байгалийн хий 600 тэрбум м³; хийн конденсат 30 сая тн хэмээн тогтоогдоод байна. Мужид цахилгаан эрчим хүч, хөнгөн цагаан, нефть боловсруулах, химийн,

ойн, мод боловсруулах зэрэг аж үйлдвэрийн томоохон салбарууд эрчимтэй хөгжиж байна.

Мөн Эрхүү муж нь Байгал нуурийн сав газарт хамаардаг гэдгийг бодолцох ёстой. Учир нь тэнд дэлхийн цэвэр усны нөөцийн 20 хувь буй гэдгийг ч санахад илүүдэхгүй билээ.

1990-ээд оноос хойш бидний хоорондын худалдаа эдийн засгийн харилцаа нь эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тасалдахад ч хүрч байлаа. Гэсэн хэдий ч одоо хамтын ажиллагаа маань өсөх хандлагатай буй нь олзуурхууштай хэрэг. Эдгээрийн хууль эрх зүйн гол үндэс нь 1998 онд байгуулсан худалдаа эдийн засаг шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны протокол, 2000 онд Эрхүү мужийн захиргаа Монгол улсын засгийн газрын байгууллагуудын хооронд байгуулсан хэлэлцээр зэргүүд болж байгаа.

Монгол улсын засгийн газар болон мужийн захиргааны хооронд байнгын яриа хэлэлцээр, уулзалтууд явагдах болсноор, бидний хоорондын харилцааны төвөгтэй асуудлуудыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Эдгээрийг батлах үзүүлэлт гэвэл дараахи хүснэгт юм.

Монгол улсаас Эрхүү мужтай хийсэн гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээ. (тухайн оны үнээр, сая ам. долл.)

үзүүлэлтүүд	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Нийт бараа								
эргэлт	42,0	33,6	32,3	47,6	47,5	57,6	91,1	140,0
Экспорт	38,0	30,7	27,8	41,1	42,7	48,4	88,2	
Импорт	4,0	2,9	4,5	6,6	4,9	9,4	2,9	
Сальдо	-24,0	-27,8	-23,3	-34,6	-37,9	-39,0	-85,3	

Дээрхи хүснэгтээс үзэхэд 1994 оноос 2001 он гэхэд манай бараа эргэлт 3,3 дахин нэмэгджээ. Орос-Монголын хоорондын бараа эргэлт ерөнхий дүнгээр буурах хандлагатай байхад бүс нутгуудаас манайтай хийсэн бараа эргэлт байнга өсөх хандлагатай байгаа. 2000 онд Монголын гадаад худалдаанд Эрхүү мужийн эзлэх хувь 9 байхад, ОХУ-ын нийт хэмжээ 36% байгаа юм. Бараа эргэлтийн байнгын өсөлтөд хил нутгийн ойролцоо орших байдал, сибирь монголын барааны харилцан бие биеэ нөхөх чанар, цаг уурын ойролцоо нөхцөл, эртний түншлэл зэргүүд нь ихэд нөлөөтэй. Мөн Засгийн газрын хэмжээнд дэмжигдэж буй нь чухал болж байна.

1999 оноос Буриад улсын төлөөлөгчийн газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулсаар ирлээ. Төлөөлөгч нь Буриадын засгийн газрын тэргүүний орлогч бөгөөд тус улсаас Ази-Номхон далайн орнуудтай харилцах газрын даргын үүрэгт ажлыг хавсран хийдэг нь энэ улсаас Зүүн Ази руу хандсан харилцаагаа Монголоор дамжуулан өргөжүүлэх сонирхолтой байгааг харуулж байна.

Эрхүү мужийн хувьд Монголд гаргаж буй экспорт нь импортоос байнга давж байна. Сүүлийн жилүүдэд Эрхүү мужаас орж ирж буй импортын 40-45% нь нефть бүтээгдэхүүн, 30% нь эрчим хүч, 8 орчим хувь нь уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж болж байна. Түүнээс гадна, 3,6% нь мод модон бүтээгдэхүүн, 2,7%-нь төмөрлөгийн бүтээгдэхүүн, 2%- орчим нь химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

2002 оны 7-р сарын 2-нд Монгол Улс дахь ОХУ-ын Элчин сайдын яаманд Эрхүү мужийн төлөөлөгчийн газрын нээлтэд зориулсан ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын үйл ажиллагааг нээж Онц бөгөөд бүрэн Эрхт элчин сайд О.М.Дерковский хэлсэн үгэндээ, Монгол, Оросын харилцаанд Эрхүү мужийн гүйцэтгэж буй үүргийг өндрөөр үнэлэн цаашид улам өргөжинө гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлсэн. Төлөөлөгчийн газрын нээлтийн ажиллагаанд оролцохоор хүрэлцэн ирсэн Эрхүү мужийн захирагч Б.А.Говорин хэлэхдээ “Оросын ард түмэн түүний дотор Сибирийнхэн монголчуудтай эрт дээр үеэс ойр дотно явж ирсэн ба бид төлөөлөгчийн газраа нээснээр энэ нөхөрлөлийг улам гүнзгийрүүлж, бидний харилцааг урьд өмнөхөөс илүү ойр дөт болгож байгаа юм” хэмээн цохон тэмдэглэсэн. Энэ үеэр Эрхүү мужийн байнгын төлөөлөгчийн газрын тэргүүн В.А.Кисловыг Монголын засгийн газар, яам, агентлагуудад танилцуулан, түүний өдөр тутмын үйл ажиллагаанд гүн туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг хүссэн. Кислов В.А. нь Эрхүүгийн захирагчийн орлогч бөгөөд Монголд дахь албан ёсны бие төлөөлөгч гэсэн албы хашиж байна.

Эрхүү мужийн захирагчийн албан ёсны айлчлалын хүрээнд Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр, Монгол-Оросын засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын Монголын хэсгийн дарга, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Худалдаа, үйлдвэрийн сайд Ч.Ганзориг нартай тус тус уулзан хамтын ажиллагааны цаашдын хөтөлбөрийн талаар ярилцан, санал солилцлоо. Зөвхөн 2001 он гэхэд Эрхүү муж, Монгол Улсын хоорондын бараа эргэлт 140 сая ам.долларт хүрч,

өмнөх жилүүдтэй харьцуулахад 47% өссөн. Энэ нь Орос, Монголын хоорондын худалдаа, бараа эргэлтийн 58% -ийг эзэлж байгаа гэсэн үг. Монгол, Эрхүүгийн худалдааны хамтын ажиллагаанд урт хугацаанд, тогтвортой байр суурийг эзэлж буй компаниудын нэг бол Ангарскийн нефть, химийн үйлдвэр бөгөөд Монголд бензин, дизель түлш, шатах тослох материалыг нийлүүлдэг. Эрхүү, Усолийн /Усольмаш/ тоног төхөөрөмж, машин техникүүд Монголын томоохон уурхайнуудыг зохих ёсоор “зэвсэглэж” байна.

Дорнод Сибирийн төмөр зам ба УБТЗ-ын хоорондын ажил төрлийн олон жилийн хэлхээ холбоо нь өнөөдөр агуулгын хувьд баяжсаар байна. Тухайн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, парк шинэчлэл, засвар үйлчилгээнд хамтрах зэргээр ажлын цар хүрээ нэлээд өргөжиж байна. Эрхүү мужийн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд Монголын зах зээлд тодорхой нэр хүндийг олж хэрэглэгчдийн сонирхлыг татах боллоо. Тийм хэдий ч бидэнд илүү нөөц бололцоо байгаа гэдгийг дурдах нь зүйтэй. Хоёр хөршүүд харилцан бие биеийгээ нөхөх замаар ажиллах нь зүйтэй бөгөөд энэ талаар хийх зүйл ч багагүй бий. Эрчим хүчнийхэн Эрхүү-Монд-Хөвсгөл-Эрдэнэт гэсэн маршрутаар эрчим хүч дамжуулах шугам барих төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй байгаа. Мөн “мянганы зам” зэрэг томоохон төслүүдэд Эрхүүгийн барилгын байгууллагууд оролцох бүрэн боломжтой юм. Монголын үндсэн нэрийн барааг Эрхүү, цаашлаад Москвад хүртэл гаргах ажлыг зохих пүүс компаниуд судлан үзэж, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ үүднээс хил, гаалийн болон бусад асуудлыг зохицуулах үүднээс хоёр тал харилцан санал солилцсон. Эрх зүй, хууль хяналтын байгууллагуудын хамтран ажиллах, ажлын үр ашгийг өндөржүүлэх зорилгоор Эрхүү мужийн захирагчийн орлогч С.Босхолов, мужийн дотоод хэргийн газрын дарга А.Россов нар Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржтой уулзан зохих баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа. Дээрхи асуудлууд ОХУ-ын Дотоод хэргийн сайд Б.Грызловын Монголд хийсэн айлчлалын үеэр ч хөндөгдөн яригдсан.